



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 10/1

Даланзадгад сум


Г

Г

“Нээлттэй Өмнөговь” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Засгийн Газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, 2022 оны 56 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Нээлттэй Өмнөговь” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д даалгасугай.
3. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгж, байгууллагын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д үүрэг болгосугай.



462000015



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
10/1 дүгээр тогтоолын хавсралт

“НЭЭЛТТЭЙ ӨМНӨГОВЬ” ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтооюор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтооюор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг улсын түвшинд хэрэгжүүлж байна.

Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг Өмнөговь аймгийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжил, ногоон хөгжил, төрийн бүтээмж сайжруулах зургаан хүрээнд Шинэ сэргэлтийн бодлогод тодорхойлсон.

Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэлд туссан.

Нутгийн удирдлагын байгууллага, бүх шатны хурлын Төлөөлөгчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоотойгоор “Алсын хараа-2050 урт хугацааны бодлого”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутгийн онцлогийг тусгасан бие даасан хөтөлбөр батлан, хэрэгжүүлэхээр нэмэлт өөрчлөлт, тодотгол хийх шаардлага гарсан.

Иймд манай аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, аймгийн түүх, соёл, зан заншил, уламжлал, оюун санааны нэгдмэл үнэт зүйлс, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилтыг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах “НЭЭЛТТЭЙ ӨМНӨГОВЬ” хөтөлбөр /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийг холбогдох бодлогын бичиг баримт, өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн зураглалд үндэслэн боловсруулсан.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, бодит нөөц бололцоо, ялгаатай байдал, бүс нутгийн эдийн засгийн чадавх, нийгэм болон байгаль орчны онцлог, орон нутгийн тогтвортой хөгжих бодлогод нийцсэн байх;

2.2. Хөтөлбөрийн хүрээнд аймаг орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсч болзошгүй хүндрэл бэрхшээлийг тооцсон бодлого хэрэгжүүлэх;

2.3. Мэдээллийн тэгш, хүртээмж байдлыг хангаж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар олгогдсон эрхийг дээдлэх, бизнес орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг бий болгох;

2.4. Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог хангасан байх;

2.5. Аймагт шилжин ирэгсэд болон нутгийн иргэдийн тэгш боломж, жигд хүртээмжтэй байдлыг хангах, хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Орон нутагт шилжин ирэгсдийн ажиллаж амьдрах орчин, иргэд, ААН, байгууллагыг үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх, аймгийн тухай нэгдсэн ойлголт, мэдээллийн сан, нэгдмэл удирдлага, зохицуулалт бүхий төрийн үйлчилгээний цахим систем бий болгох, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

4.1. Аймгийн онцлог, байгаль, түүх, соёлын ялгаатай байдал, харьцангуй давуу тал, одоо ба ирээдүйн боломжийг улс, бус нутгийн хэмжээнд таниулах;

4.2. Аймгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн олон тулгуурт бодлого хэрэгжүүлэх, аймгийн хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг үе шаттайгаар бууруулах;

4.3. Иргэдэд ажиллаж амьдрах, аж ахуйн нэгж байгууллагад үйл ажиллагаа явуулах таатай орчныг бүрдүүлэх;

4.4. Мэргэжлийн ажиллах хүчний хомсдолыг багасгах, үүссэн сул орон тоог нөхөх албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр сургалт явуулах зэргээр зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжих;

4.5. Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээнд цахим шилжилтийг түргэтгэж, шуурхай, цэгтэй, байнгын ойлгомжтой үйлчилгээ бий болгох.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1. Амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт татах чиглэлд идэвх санаачлага гаргах;

5.2. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх, аймагтаа салбар нээж, ажлын байр нэмэгдүүлэх;

5.3. Боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн байгууллагын сул орон тоог нөхөх,

5.4. Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон сурталчлах;

5.5. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, тэднийг аймаг орон нутагт шилжин ирж суурьшин амьдрах сэдлийг төрүүлэх, хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах;

5.6. Иргэдийн шилжилт хөдөлгөөний талаарх харилцааг зохицуулж байгаа хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талын судалгаа хийх, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

5.7. Иргэд, хуулийн этгээдийн бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг цахимд шилжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон техиник хэрэгслийн хүчин чадлын нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах;

5.8. Шилжин суурьших иргэдийн хөдөлгөөнтэй холбоотой гарч болох гэмт хэрэг, зөрчлийг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулах;

5.9. 2023 оныг Монголд зочлох жил болгон зарлаж байгаатай холбогдуулан хөтөлбөр хэрэгжих хугацаанд “Өмнөговьд зочлох” жил болгож, соёлын аялал жуучлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлэх;

5.10. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллага, уул уурхайн компаниудтай хамтын ажиллагааг идэвхижүүлж ажилтан албан хаагчдыг орон нутагт шилжин ирж ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

5.11. Хөдөлмөрийн тухай хуулийн 92, 144-р зүйлийн хэрэгжилтийг ханган ажиллахад орон нутгаас хамтын ажиллагааны хүрээнд үүрэг чиглэл өгч мэрэгжлийн байгууллагатай нягт уялдаатай ажиллах;

5.12. Хүн амын өсөлттэй уялдуулан нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, аймгийн хөтөлбөрүүдтэй уялдуулах замаар иргэдийг амьжиргааг дээшлүүлэх;

5.13. Байгууллага, аж ахуй нэгжүүдэд эцэг эхийн зөвлөлийг байгуулан, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, гэр бүл хүүхдэд ээлтэй байгууллага болгох;

5.14. Шилжин суурьшиж буй гэр бүлүүдэд гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн зерэг аргыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын хамгаалал, хувь хүний хөгжил, амьдрах ухааны чадвар олгох сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах;

5.15. Шилжин суурьшиж буй залуу гэр бүлүүдийн гэр бүлийн гишүүдийг идэвхжүүлэх, нийгмийн амьдралд оролцуулах зорилгоор дэмжих бүлгүүдийг байгуулан, үйл ажиллагааг зохион байгуулах.

5.16. Дотоод, гадаад болон хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, зочид буудал, зоогийн газар, амралт зугаалгын орчин, зорих газар, зочлох үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн Засаг даргын орлогч байна.

6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална. Ажлын хэсэг нь 16 хүртэл гишүүнтэй байх бөгөөд (хамтын ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн гэх мэт) ажилтны төлөөлөлтэй байна. Түүнчлэн УБ хот дахь нутгийн зөвлөл, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын төлөөллийг зөвшилцлээр оруулж болно.

6.3. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

6.4. Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бус нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал, зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах асуудлыг Ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргатай зөвшилцэн, Засаг

даргын удирдлагын зөвлөлийн хурал болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.5. Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн хэмжээнд шинээр буй болсон ажлын байр, тухайн салбарт дутагдаж буй шаардлагатай боловсон хүчний судалгаа, шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлсэн байна. Улмаар төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох ажлыг орон нутаг дахь бүртгэл хариуцсан ажилтан шуурхай зохион байгуулна.

6.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

ДОЛОО. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

7.1. Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 оны нэгдүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

7.2. Хөтөлбөрийн хоёрдугаар шатыг 2024 оны нэгдүгээр улирлаас 2028 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- 8.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- 8.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө;
- 8.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусlamжийн хөрөнгө;
- 8.1.4. Бусад.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

9.1.1. Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 20%-иас дээш нэмэгдсэн эсэх;

9.1.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуучлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо;

9.1.3. Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо;

9.1.4. Иргэд, ААН байгууллагууд, олон нийтрүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;

9.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын “Хүн амын нэмэгдэлтийн хувь, төсвийн байгууллага, хуулийн этгээд тэдгээрийн салбар нэгжийн болон албан хаагчийн шилжилтийн хувь” шалгуур үзүүлэлтээр хэрхэн дүгнэгдсэн байдал;

9.2. Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.